



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/385

Хэрлэн сум

Ур чадварын тэмцээнийг зохион
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн 02 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд зарлагдсан “ШИЛДЭГ СУВИЛАГЧ” болзолт уралдааны 3 дахь шатны шалгаруулалт болох ур чадварын тэмцээнийг зохион байгуулахад 2,224,000 (хоёр сая хоёр зуун хорин дөрвөн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Ур чадварын тэмцээний зардлыг хавсралтаар баталсугай.


3. Үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Доржханд)-д даалгасугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэнд, Боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-д, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д, тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Ур чадварын тэмцээний төсөв:

№	Зардалын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шүүгч багш нарын үдийн хоол	3* хүн*2 өдөр*2 удаа	17000	204.000
2	Буудал	3 ортой өрөө 2 өдөр	140000	280.000
3	Шуудангийн зардал	3 хүн*2	35000	210.000
4	Багшийн цагийн хөлс	3 хүн	500.000	1.500.000
6	Бичиг хэргийн зардал	-	30.000	30.000
Нийт дүн				2.224.000 төгрөг